

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2022.07.28

Борхойн тал

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 06 дугаар сарын 30	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс логистикс ХК, ETR, 99117636	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	БиДиСек ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ	
Жилийн эцсийн санхүүгийн тайланда аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа	
1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн	316,215,821.25
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,667,392,821.11
	Нийт хөрөнгийн дүн	4,983,608,642.36
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,221,374.57
	Өр төлбөрийн нийт дүн	26,221,374.57
	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,957,387,267.78
	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,983,608,642.78

	Орлогын тайлан	Борлуулалтын орлого (цэвэр)	343,565,727.27
		Нийт ашиг (алдагдал)	343,565,727.27
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(168,363,503.33)
		Татварын дараах ашиг (алдагдал)	(168,363,503.33)
		Нийт орлогын дүн	(168,363,503.33)
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч	4,620,000,000.13
		Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00
		Эздийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00
		Хуримтлагдсан ашиг	(591,470,812.35)
		Нийт дүн	4,957,387,267.78
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	423,497,312.12
		Мөнгөн зарлага (-)	452,219,912.37
		Цэвэр мөнгөн гүйлгээ	(28,722,600.25)
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	-
		Мөнгөн зардагын дүн (-)	95,642,640.00
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(95,642,640.00)
		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(124,365,240.25)
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,981,170.51
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		

	Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тус зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Э.Батболд, Х.Бат-Эрдэнэ, Ч.Оргил нарын бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тус хорооноос компанийн санхүүгийн тайланг жилд нэг удаа жилийн эцсээр хэлэлцэхээр шийдвэрлэсний дагуу улирал, хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцээгүй болно.												
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтуүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт												
	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан БНХАУ хилээр оруулах бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтэнд хязгаарлалт тогтоосонтой холбоотой тус компанийн үндсэн үйл ажиллагаа ерөнхийдөө бүрэн зогссон байдалтай байгаа болно. Энэхүү байдлаас шалтгаалан компанийн санхүүгийн байдал өнөөдрийн байдлаар 168,363,503.33 төгрөгийн алдагдалтай гарсан. Удирдлагын зүгээс үйл ажиллагаагаа бүрэн зогсоохгүй, санхүүгийн байдлаа дордуулахгүй байх тал дээр онцгой анхаарч үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэр дэх хамтран ажиллагч байгууллагуудтай нягт хамтарч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар импортоор орж ирж байгаа техник тоног төхөөрөмж, төрөл бүрийн тээврийн хэрэгсэлийг компанийн гаалийн хяналтын бүсэд хүлээн авч гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн ажил хийгдэж байна. Бoomтын өргөтгөлтэй холбоотой тус боомтод үйл ажиллагаа явуулж байсан авто пүүг зогсоох болсонтой холбоотой тус компанийн пүүг ашиглах хүсэлтийг Замын-Үүд дэх гаалийн газраас ирүүлсний дагуу гаалийн хяналт шалгалтанд авто пүүгээ ашиглалаа болсон ба ингэснээр дээрх импортын ачаа бараанууд зөвхөн тус компаниар дамжихаар болсон. Мөн 2022 оны 05 сард Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөөнөөс БНХАУ-аас задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачигдан импортоор оруулж ирж байгаа ачаа бараа төмөр замын тээвэрлэлтийн шаардлага хангахгүй орж ирж байгааг тус компанийн салбар замаар оруулан зөрчлийг арилгуулуулах хүсэлт гаргасны үндсэн дээр компанийн техник тоног төхөөрөмжийг ашиглан зөрчлийг засуулах ажлыг зохион байгуулж байна. Компанийн гадна дотно орчныг сайжруулах, ажиллагсад болон үйлчлүүлэгч нарын ая тухтай байдлыг хангах үүднээс тохижолтын ажлыг хийж гүйцэтгэж officсын гадна талын засварын ажлыг хийж дуусган гаалийн хяналтын бүсийн талбайг бетонон хучилттай болгох ажлыг эхлүүлээд байна.												
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/												
	Нийт ашгийн хувь: 100% /өртөггүй/ Цэвэр ашгийн хувь: -49.15% Нийт хөрөнгийн өгөөж (ROA): -3.37% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): -3.39% Эргэлтийн харьцаа: 12.05 Түргэн хөрвөх чадварын харьцаа: 4.49												
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт												
	<table border="1"> <thead> <tr> <th colspan="3">Хөрөнгийн байдлын үнэлгээ</th> </tr> <tr> <th>Төрөл</th> <th>Үзүүлэлт</th> <th>Дүгнэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td>2022 он</td> <td>Үндсэн хөрөнгөнд өсөлт гараагүй.</td> </tr> <tr> <td>Хөрөнгийн өсөлтийн хурд</td> <td>96.9%</td> <td></td> </tr> </tbody> </table>	Хөрөнгийн байдлын үнэлгээ			Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт		2022 он	Үндсэн хөрөнгөнд өсөлт гараагүй.	Хөрөнгийн өсөлтийн хурд	96.9%	
Хөрөнгийн байдлын үнэлгээ													
Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт											
	2022 он	Үндсэн хөрөнгөнд өсөлт гараагүй.											
Хөрөнгийн өсөлтийн хурд	96.9%												

		Эргэлтийн хөрөнгийн жин	хөрөнгийн	6.34%	Эргэлтийн хөрөнгийн эзлэх жин бага хөрвөх чадвар сул, үндсэн хөрөнгө ихтэй.
		Элэгдлийн хувь			
Санхүүгийн байдлын үнэлгээ					
	Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт		
		2022 он		Aжлын капитал сайн ба эргэлтийн харьцаа 12.05 байгаа нь үйл ажиллагаанд богино хугацааны санхүү дарамт байхгүйг илэрхийлж байна.	
	Ажлын капитал	289,994,446.68			
	Ажлын капиталын оролцоо	91.7%		Эргэлтийн хөрөнгийн 91.7% хувийг байнгын капиталаар санжүүжүүлж байна.	
	Эргэлтийн харьцаа	12.05		Эргэлтийн хөрөнгөөр БХӨТ-ийг барагдуулах чадвар сайн ба тус үзүүлэлт БХӨТ-н дүн буурсанаар өмнөх оны жилийн эцсээс 2 дахин нэмэгдсэн байна.	
	Бие даалтын коеф	6<9.94		Урт хугацаат өр төлбөргүй, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ бага байгаа нь компанийг өрийн дарамтгүй бие даан үйл ажиллагаа явуулах чадамж сайтайг илэрхийлж байна.	
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл				

Компанийн үйл ажиллагаанд өнөөдрийн байдлаар хамгийн ихээр нөлөөлж байгаа асуудал бол цар тахал түүнээс улбаалсан хилийн хорио цээр, ачаа барааны тээвэрлэлтийн байдал болоод байна. 2021 оны 10 сараас зогсонго байдалтай байгаа импортын ачааны байдлаас шалтгаалан шилжүүлэн ачилт, гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа бүрэн зогссон байдалтай байгаа нь компанийн санхүүгийн байдлыг ихээхэн дордуулж байна. Компани нь өөрөө бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компани биш учраас гадаад, дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаа нь тогтмол өөрчлөгджэй байдаг. Тийм ч учраас компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр цар тахлын нөхцөл байдалд тохируулан үйл ажиллагаагаа явуулах бодлого баримтлан ажиллаж байгаа ба компанийн техник тоног төхөөрөмж, хүн хүч, газар нутгийн байрлал, хяналтын бүсийн багтаамж зэрэг ижил үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс аль болох давуу талаа ашиглан ажиллаж байна. Цаашид хилийн хорио цээрийн нөхцөл байдал сайжиртал компанийн санхүү, үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах чиглэлд шаардлагатай ажил үйлчилгээг тухайн үед нь шийдвэрлэн ажиллахаар төлөвлөсөн болно.

д/д	Орлогын нэр	2021 оны хагас жил	2022 оны хагас жил	Зөрүү
1	Ачилтын орлого	42,477,818	4,090,182	-38,387,336
2	Хадгалалт болон гарах хуудас	695,974,005	279,558,000	-416,416,005
3	Түрээсийн орлого	28,068,182	14,545,455	-13,522,727
4	Бусад орлого	39,783,000	59,917,545	20,134,545

3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
		Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
		- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээжит хурлыг 2022 оны 04 сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн: Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

	<p>Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан</p> <p>Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах</p> <p>Компанийн 2022 оны стратеги төлөвлөгөөг батлах</p> <p>ТҮЗ-ийн 2022 оны цалин урамшууллын төсөв батлах</p> <p>ТҮЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох</p> <p>Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах</p> <ul style="list-style-type: none"> - Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь улиран сонгогдсон бөгөөд гишүүдийн хурлыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр эчнээгээр зохион байгуулан төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг томилсон. - 2021 оны жилийн санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнаалд ИхМонгол хөлөг аудит ХХК-иар аудит хийлгэн аудитын дүгнэлт тайлагнаалыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. - Компанийн цахим хуудсыг шинэчлэн бэлэн болгосон. Компанийн засаглалын кодекст тогтоож өгсөн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам заавар, үйл ажиллагаа, санхүүгийн тайлагнаалууд зэрэг баримт бичгүүдийг хувьцаа эзэмшигчидэд шууд үзэх болон татаж авах байдлаар хийж байршуулсан. Цаашид цахим хуудас болон сошиал хуудаснуудын байнгын ажиллагааг хангаж ажиллахад анхаарч ажиллана. - Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагнаалуудыг хууль журмаар тогтоосон хугацаанд нь гарган Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллаж байгаа ба Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тайлагнаалуудыг тогтмол байршуулж байна. 		
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл		
	Компанийн засаглалын кодекс шинэчлэгдсэнтэй холбоотойгоор засаглалтай холбоотой шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.		
	Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
	<table border="0"> <tr> <td style="vertical-align: top;"> <p>Овог, нэр: Чулуун Амарсанаа</p> <p>Албан тушаал: "Э-Транс логистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p>  </td><td style="vertical-align: top;"> <p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал: "ИхМонгол хөлөг аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p> </td></tr> </table>	<p>Овог, нэр: Чулуун Амарсанаа</p> <p>Албан тушаал: "Э-Транс логистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p> 	<p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал: "ИхМонгол хөлөг аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p>
<p>Овог, нэр: Чулуун Амарсанаа</p> <p>Албан тушаал: "Э-Транс логистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p> 	<p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал: "ИхМонгол хөлөг аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p>		
	Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		

Овог, нэр: Содномцэрэн Ганбат

Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан

Гарын үсэг:  2022.07.20